

**ЗӨВШӨӨРӨВ:**

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.ЭРДЭМБИЛЭГ  
*Ц.Эрдэмбилэг*

**БАТЛАВ:**

ЕРӨНХИЙ МЭРГЭЖЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

*Д.Мягмарцэрэн* Д.МЯГМАРЦЭРЭН

**ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“ӨРХИЙН АНАГААХ УХААН СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Индекс:** S(r) 091212

**Хугацаа:** 2 жил

**УЛААНБААТАР**

**БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

Д.Мягмарцэрэн	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор
Н.Сүмбэрзул	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эрдмийн сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, Профессор
Д.Мөнхцэцэг	Эх барих эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор
С.Эрдэнэ	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэс заслын тэнхимийн ахлах багш, Дурангийн мэс заслын нийгэмлэгийн тэргүүн, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй эмч
Н.Бат-Эрдэнэ	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Зүрх судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр
А.Цолмонтuya	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн багш, Нийгмийн эрүүл мэндийн магистр

**Хянасан:**

П. Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 9 сарын 01.-ны өдрийн 09-р тогтоолоор зөвшөөрөв.

## ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ӨРХИЙН АНАГААХ УХДАН СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Өрхийн анагаах ухаан нь эрүүл мэндийн анхан шатны тусlamжийн чиглэлээр дагнасан анагаах ухааны нэгэн салбар ухаан /discipline/, бас тусгайлсан нэгэн нарийн мэргэжил /speciality/ мөн бөгөөд хувь хүн, гэр бүлийн гишүүд болон тодорхой хамт олонд тэдний нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг болон эрүүл мэндийн байдлыг ялгаварлахгүйгээр эрүүл мэндийн иж бүрэн тусlamж үзүүлэх зорилготой.

2018 оны Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын бүх гишүүн орнуудын баталсан Астанагийн тунхаглалаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралтанд хүрэх тулгын чулуу нь эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ болохыг баталгаажуулсан. Өрхийн анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ нь эрүүл мэндийн тогтолцооны үндэс суурь юм.

Монгол улсын хэмжээнд эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлдэг 536 эмнэлгийн байгууллага байгаа бөгөөд эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээний олон талт үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх асуудал чухал болоод байгаа тул тэдгээрт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшсэн өрхийн эмчийг бэлтгэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Өрх гэрийн дотны туслагч, зөвлөгч, гишүүн байж хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусlamжийг чанар, хүртээмжтэй үзүүлэхийн тулд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, нас, хүйсийн мэдрэмжтэй хандаж нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг зохион байгуулах, багаар ажиллах, тасралтгүй суралцах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн эрүүл мэндийн анхан шатны цогц тусlamж үйлчилгээг үзүүлэхүйц ёс зүйтэй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллах чадвар бүхий мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

### ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Өрхийн анагаах ухаан судлалаар мэргэшсэн эмч нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх мэдлэг, хандлага, ур чадвар бүхий, хүний эрхийг эрхэмлэн дээдэлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримталдаг, эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий мэргэжилтэн болсон байна.

## ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Үндсэн мэргэшлийн сургалтын төгсгөлд Өрхийн эмч нь дараах чадамжийг эзэмшина.

1. Ерөнхий мэргэшлийн эмч (*General Practitioner*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Цогц чадамж бүхий эмч болохын тулд дор дурдсан чадамжийг эзэмшиж, бие дааж гүйцэтгэж чаддаг болно.

### 1. Ерөнхий мэргэшлийн эмч байх (*General Practitioner*)

- Эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээний мөн чанарыг ухамсарлаж, хүн амд чанартай, хүртээмжтэй тусlamж үйлчилгээ үзүүлэх хандлага эзэмших,
- Өрх гэр бүл, бүлэг хүн амын эрүүл мэндэд нөлөөлөгч нийгмийн болон биологийн хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх чадварт суралцах,
- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдгийг таньж ялган оношлох, анхан шатны арга хэмжээг авах,
- Үйлчлүүлэгчээс асуумж авах, бодит үзлэг хийх, үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх,
- Орон нутгийн түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусlamж, үйлчилгээг аюулгүй үзүүлэх,
- Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах,
- Үйлчлүүлэгчийн өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах,
- Орон нутгийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, үйлчлүүлэгчид үзүүлэх тусlamж, үйлчилгээг шийдвэрлэх,
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх,

### 2. Мэргэжлийн байх (*Professionalism*)

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх,
- Үйлчлүүлэгчийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах,
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах,

### 3. Суралцагч байх (*Learner*)

- Үйл ажиллагааныхаа чиглэлээр мэдээллийн сан бий болгох, үүсгэсэн мэдээллийн санд энгийн анализ хийж, үр дүнг тайлбарлах, танилцуулах,
- Мэдлэг, үр чадвараа тасралтгүй дээшлүүлэхийн тулд хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай сургалтад хамрагдах,

- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах,
- Олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судалж, дүн шинжилгээ хийснээр нотолгоотой мэдээллийг сонгон авч өдөр тутмын үйл ажиллагаандaa ашиглах,
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.

#### **4. Харилцагч байх (*Communicator*)**

- Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах,
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах,
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

#### **5. Хамтрагч байх (*Collaborator*)**

- Орон нутгийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар холбогдох мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцож, хамтран ажиллах,
- Хамтран ажиллагсад, бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.

#### **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (*Community Health Advocate*)**

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусlamж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах,
- Хувь хүн ба өрх гэрийн гишүүд /хүүхэд, өсвөр үе, настан, эрэгтэй, эмэгтэй/, бүлэг хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан болон бүлгийн сургалт, зөвлөгөө өгөх чадвар эзэмших.

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*Organizer, Leader*)**

- Эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, манлайлан ажиллах,
- Эрүүл мэндийн төв дэх тусlamж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах.

### **ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ**

#### **5.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил**

- Сургалтыг нийт 18 чиглэлээр тойролт хийж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, Амилуулах суурь тусlamж, Халдварын сэргийлэлт, хяналт, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хуулийн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.
- Сургалтын хугацаа 2 жил байна.
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь сургалтын үндсэн байгууллага байна.

- Өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, Нийслэлийн Өргөө, Амгалан амаржих газар, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Эффект эмнэлэг, Монгол Япон эмнэлэг, Геронтологийн үндэсний төв зэрэг эрүүл мэндийн байгууллагуудтай сүлжээ үүсгэн ажиллана.

## **5.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл**

Сургалтын төгсгөлд эмнэл зүйн талбарт бие даан тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадвар, дадлага эзэмшихийн тулд эмнэл зүйн сургач багшийн удирдлага дор амбулаториор болон хэвтэн эмчлүүлэх өвчтөнийг оношлох эмчлэхдээ дор дурдсан шинж тэмдгээр гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

### **5.2.1 Шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод тохиолдох)**

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялан оношилгоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Ам цангах (*thirsty*)
2. Амнаас эвгүй үнэр гарах (*halitosis*)
3. Амьсгаадах (*Shortness of breath*)
4. Амьсгал давчдах (*Dyspnea*)
5. Анхаарал төвлөрөлт алдагдах (*loss of concentration*)
6. Архи хэтрүүлэн хэрэглэх (*Abuse of alcohol*)
7. Арьс загатнах (*itchy skin*)
8. Арьсны холголт цооролт (*pressure ulcer*)
9. Бөөлжих (*vomiting*)
10. Булчингийн чангараал (*muscle stiffness*)
11. Бэлгийн сулрал (*impotence*)
12. Гиперкальциеми (*hypercalcemia*)
13. Гэнэт хэсэгчлэн/түр хараагүй болох/харааны талбай багасах (*Sudden partial/temporary loss of vision/loss of visual field*)
14. Гялтангийн хөндийд шингэн хурх (*Pleuritis*)
15. Дотор муухайрах (*Nausea*)
16. Дуу хоолой өөрчлөгдөх (*Alteration of voice*)
17. Жирэмсний аюултай шинж (*Dangerous signs of pregnancy*)
18. Зан авир гэнэт өөрчлөгдөх (*Acute change in behavior*)
19. Зүрх дэлсэх (*Tachycardia*)
20. Зүрх зогсох (*Cardiac arrest*)
21. Их уух/их шээх (*polydipsia/polyuria*)
22. Лимфийн булчирхайн томролт (*Lymph node swelling*)
23. Манас таталт (*Manas convulsions*)
24. Мөчдийн саажилт (*Paralysis*)
25. Мөчдийн цочмог өвдөлт (*Acute pain in limbs*)
26. Настны сонсгол/хараа бууралт (*Hearing/vision impairment in elderly person*)
27. Настны хоол тэжээлийн дутмагшил (*Malnutrition in elderly people*)

28. Нойргүйдэх (*Insomnia*)
29. Нугасны язгуурын дарагдлын хам шинжүүд (*Spinal root compression syndromes*)
30. Цавины өвдөлт (*Groin pain*)
31. Нурууны өвдөлт (*Back pain*)
32. Нүд гэрэлд гялбах (*Photophobia*)
33. Нүд хуурайших хам шинж (*Kerato-conjunctivitis sicca*)
34. Нүдний салстын үрэвсэл (*Conjunctivitis*)
35. Нүдэнд оч гялбах (*Light flashes (photopsia)*)
36. Ой тогтоолт муудах (*Memory loss*)
37. Оир ойрхон шээх (*frequent urination*)
38. Оюун санааны бэрхшээл (*Mental problems*)
39. Өвдөлт (*Pain*)
40. Өвдөлттэй шээх (*Dysuria*)
41. Өнгөц болон гүний мэдрэхүй алдагдах (*Loss of superficial and deep sensation*)
42. Өтгөн хатах (*Constipation*)
43. Саа, саажил (*Paralysis*)
44. Санаа зовох/сандрах/цочмог стресс (*Nervousness/tension/anxiety/acute stress*)
45. Сандрах, түгших (*Agitation*)
46. Сонсголын бэрхшээл (*Hearing impairment*)
47. Сувгийн хамшинж (*Carpal tunnel syndrome*)
48. Суулгалт (*Diarrhea*)
49. Сэтгэл гутрал (*Depression*)
50. Сэтгэхүйн үйл ажиллагаа буурах (*Decreased cognitive function*)
51. Таргалалт (*Obesity*)
52. Таталт (*Seizure*)
53. Толгой өвдөлт (*Headache*)
54. Толгой эргэх (*Dizziness*)
55. Тунгалгийн булчирхай томрох (*Enlargement of lymph nodes*)
56. Турах (*Lose weight*)
57. Тууралт (*Rash*)
58. Тэнцвэр алдагдах (*Loss of vestibular*)
59. Ухаан алдалт, баларталт (*Altered level of consciousness*)
60. Үе мөчний хөдөлгөөн, хүч буурах (*Reduction of strength and joint motility*)
61. Үе хавдах (*Swollen joints*)
62. Үений өвдөлт (*Arthralgia*)
63. Үений хэлбэр алдагдах (*Deformities of joints*)
64. Үргүйдэл (*Infertility*)
65. Үс унах, халцрах (*Lack of hair/alopecia*)
66. Хаван (*Edema*)
67. Халдвэр хордлогын шок (*Infectious toxic shock*)
68. Халууралт (*Fever*)
69. Хамар битүүрэх, нусгайрах (*Nasal obstruction/nasal discharge*)
70. Хамраас цус гоожих (*Nose bleed*)

71. Ханиалгалт, цэр гаралт (*Cough, Excretions sputum*)
72. Хараа аажим буурах (*Slow loss of vision*)
73. Харааны бэрхшээл (*Visual impairment*)
74. Хоолой багтрах (*Gasp for breath*)
75. Хоолой өвдөх (*Sore throat*)
76. Хоолонд дургүй болох (*Loss of appetite*)
77. Хөдөлгөөний бэрхшээл (*Mobility impairment*)
78. Хурхирах (*Snoring*)
79. Хүзүү хөших (*Stiffness of neck*)
80. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл (*Disability of children*)
81. Хэвийн бус амт мэдрэгдэх (*Altered taste sensation/dysgeusia*)
82. Хэвлийн өвдөлт (*Stomachache*)
83. Хэвлийн хөндийд шингэн хурах (*Ascites*)
84. Хэл ярианы бэрхшээл (*Speech impairment*)
85. Цус алдалт (*Hemorrhagic tendency*)
86. Цус багадалт (*Anemia*)
87. Цус харвалтын дараах хам шинж (*Post stroke syndrome*)
88. Цусаар шээх (*Blood in urine/Hematuria*)
89. Цусны даралт буурах (*Low blood pressure*)
90. Цусны даралт ихсэх (*High blood pressure*)
91. Цустай бөөлжилт (*Hematemesis*)
92. Цустай өтгөн, цустай гүйлгэлт (*Melena*)
93. Цэр гаралт (*Excretions sputum*)
94. Цээж хорсох (*Heartburn*)
95. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
96. Чих өвдөх (*Ear ache*)
97. Чих шуугих (*Tinnitus*)
98. Чихнээс булаг гарах (*Discharge from ear*)
99. Шарлалт (*Jaundice*)
100. Шингэн алдалт (*Dehydration*)
101. Шээс задгайрах (*Urine incontinence*)
102. Шээс хаагдах (*Urinary retention*)
103. Шээсний сүвээс ялгадас гарах (*Urethral discharge*)
104. Эмгэг рефлекс үүсэх (*Pathological reflexes*)
105. Юм хоёрчлогдож харагдах (*Double vision/diplopia*)
106. Ядарч сульдах (*Fatigue*)
107. Ялимгүй зовлонт байдал (*Obsessive-compulsive symptoms*)

### **5.2.2. Өвчин (Тойролт тус бүрээр)**

#### **Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд**

1. Уушгины хатгаа – *Pneumonia* (J18.0)
2. Гуурсан хоолойн үрэвсэл – *Bronchitis* (J20.0)
3. Төвөнхийн үрэвсэл – *Laryngitis* (J04.0)
4. Гуурсан хоолойн багтраа – *Asthma* (J45.0)

5. Суулгалт – *Diarrhea* (K52.0)
6. Цагаан хорхойтох – *Helminthiasis* (B65.0)
7. Рахит – *Rickets* (E55.0)
8. Цус багадалт – *Anemia* (D50.0)
9. Хоол тэжээлийн дутагдал – *Malnutrition* (E40-E46)
10. Шүүдэст эмзэгшил - *Diatez*
11. Тууралт өвчин - *Skin rash*
12. Нярайн шарлалт - *jaundice* (P58)
13. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх - *Screening disability of children*

#### **Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд**

1. Фимоз – *Phimosis* (N47.1)
2. Парафимоз – *Paraphimosis* (N47.2)
3. Түрүү булчирхайн томрол - *Benign prostatic hyperplasia* (N40.0)
4. Цавиниы ивэрхий – *Inguinal hernia* (K40)
5. Таргалалт – *Obesity* (E66.0)
6. Бэлгийн сулрал – *Impotence* (N52)
7. Үргүйдэл – *Infertility* (N46)
8. Бэлгийн замаар дамжих халдвэр – *Sexual transmitted disease* (A50-A64)
9. Эрэгтэйчүүдийн цэвэршилт – *Male menopause* (N95)

#### **Эх барих, эмэгтэйчүүд судлал**

1. Жирэмсний хяналт (Эрүүл, өртөмхий) - *Prenatal care (Healthy, susceptible)*
2. Жирэмсний үеийн эмгэг - *Antenatal care*
3. Перинатал үеийн асуудал, төрөх үеийн тусламж (Эмнэлгийн бус нөхцөлд төрөлт удирдах) - *Perinatal care, Assisting delivery*
4. Перинатал үеийн асуудал, нярайн тусламж (нярайн эрт үеийн нэн яаралтай тусламж) - *Perinatal care, Newborn care*
5. Төрсний дараах тусламж үйлчилгээ - *Postnatal care*
6. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин - *Gynecologic inflammatory diseases*
7. Бэлгийн замаар дамжих халдвэр - *Sexually transmitted disease*
8. Гэр бүл төлөвлөлт - *Family planning*

#### **Настны эрүүл мэнд**

1. Тэнэгрэл, Альцхаймерийн өвчин – *Dementia in Alzheimer's disease* (G30)
2. Паркинсонизм - *Parkinson's disease* (G20)
3. Сэтгэл гутрал – *Depression* (F32)
4. Түрүү булчирхайн томрол – *Benign prostatic hyperplasia* (N40.0)
5. Шээс хаагдах - *Urinary retention* (R33.9)
6. Шээс задгайрах – *Urinary incontinence* (N39.3-N39.4)
7. Цэвэршилтийн үеийн хямрал – *Menopause* (N95)
8. Настны чихрийн шижин – *Diabetes Mellitus* (E11)
9. Настны даралт ихсэх эмгэг – *Arterial hypertension* (I11)
10. Настны титэм судасны хомсдол – *Ischemic heart disease* (I25)
11. Настны тархины цусан хангамжийн хомсдол – *Cerebrovascular disease* (I67)
12. Яс сийрэгжиж өвчин – *Osteoporosis* (M81.0)

## **Зонхилон тохиолдох халдварт бус өвчин**

1. Уушгины хатгаа – *Pneumonia* (J18.0)
2. Бронхит – *Bronchitis* (J20)
3. Багтраа – *Asthma* (J45)
4. УАБӨ – *Chronic obstructive pulmonary disease* (J44.9)
5. Уушгины хавдар – *Lung cancer* (C34)
6. Ходоодны архаг үрэвсэл – *Chronic gastritis* (K29)
7. Улаан хоолойн сөөргөө өвчин – *Gastroesophageal reflux disease* (K21)
8. Элэгний хатуурал – *Liver cirrosis* (K74)
9. Элэгний хавдар – *Liver cancer* (C22)
10. Нойр булчирхайн архаг үрэвсэл – *Chronic pancreatitis* (K86)
11. Цусны даралт ихсэлт – *Arterial hypertension* (I11)
12. Зүрхний шигдээс – *Heart attack* (I21)
13. Чихрийн шижин - *Diabetes Mellitus* (E11)
14. Архаг гломерулонефрит – *Chronic glomerulonephritis* (N03)
15. Пиелонефрит - *Chronic pyelonephritis* (N11)

## **Мэс засал**

1. Хатиг, буглаа – *Cutaneous abscess, furuncle and carbuncle* (L02)
2. Мастит – *Mastitis* (N61)
3. Панариц – *Panaritium* (L03)
4. Мухар олгойн цочмог үрэвсэл – *Acute appendicitis* (K35)
5. Нойр булчирхайн цочмог үрэвсэл - *Acute pancreatitis* (K35)
6. Цэсний хүүдийн цочмог үрэвсэл - *Acute cholecystitis* (K81)
7. Цэсний чулуу – *Gallstone/Cholelithiasis* (K80)
8. Ходоод гэдэсний замын цус алдалт - *Gastrointestinal bleeding* (K92)
9. Хэвлийн гялтангийн үрэвсэл – *Peritonitis* (K65)

## **Осол гэмтэл**

1. Мөр ба бугалгын гэмтэл – *Injuries to the shoulder and upper arm* (S40-S49)
2. Тохой ба шууны гэмтэл – *Injuries to the elbow and forearm* (S50-S59)
3. Бугуй ба сарвууны гэмтэл – *Injuries to the wrist, hand and fingers* (S60-S69)
4. Түнх ба гуя орчмын гэмтэл – *Injuries to the hip and thigh* (S70-S79)
5. Өвдөг ба шилбэний гэмтэл – *Injuries to the knee and lower leg* (S80-S89)
6. Шагай ба тавхайн гэмтэл – *Injuries to the ankle and foot* (S90-S99)
7. Түлэгдэлт - *Burns and corrosions of external body surface* (T20-T25)
8. Хөлдөлт - *Frostbite* (T33-T35)

## **Яаралтай тусламж**

1. Толгой, хүзүү, нурууны гэмтэл (суурь тусламж, тээвэрлэлт) (*Head, neck and spine injury (initial management and transportation)*)
2. Түлэгдэл, хөлдөлт (*Burn and frost-bite*)
3. Амьсгалын зам гадны биетээр бөглөрөх, живэх (*Foreign body obstruction, Drowning*)
4. Ясны хугарал (*Fracture*)
5. Тархинд цус харвах (цочмог үеийн) (*Stroke (acute phase)*)

6. Зүрхний дутагдал, зүрхний шигдээс (цочмог үеийн) (*Heart failure, Myocardial infarction (acute phase)*)
7. Шок (*Shock*)
8. Цочмог хордлого (*Poisoning, Intoxication*)
9. Могой, шавжид хатгуулах (хачиг) (*Snake bite, insect bite (tick bite)*)
10. Буглаа (*Abscess*)

#### **Сэтгэцийн эрүүл мэнд**

1. Сэтгэл түгшил – *Anxiety* (F41)
2. Сэтгэл гутрал – *Depression* (F32)
3. Архины хэрэглээтэй холбоотой эмгэгүүд – *Alcohol related disorders* (F10)
4. Нойрны эмгэг – *Sleep disorders* (F51)
5. Архаг ядаргаа – *Chronic fatigue* (F48)
6. Тайлбарлаж боломгүй бие махбодийн зовиур - *Somatoform disorders* (F45)
7. Тэнэгрэл – *Dementia* (F02)
8. Оюуны хомсдол - *Intellectual disabilities* (F70-F79)
9. Аутизм - *Autism* (F84.0)

#### **Мэдрэл судлал**

1. Хүчилтөрөгч дутлын энцефалопати - *Hypoxic ischemic encephalopathy* (P91.6)
2. Хүүхдийн тархины саа – *Cerebral palsy* (G80)
3. Эпилепси – *Epilepsy* (G40.0)
4. Мигрень – *Migraine* (G43)
5. Талсаажил - *Hemiplegia and hemiparesis* (G81)
6. Иж саа ба дөрвөл саа - *Paraplegia and quadriplegia* (G82)
7. Тархмал хатуурал - *Multiple sclerosis* (G35)
8. Невропати – *Neuropathy* (G60)
9. Полиневропати - *Polyneuropathy* (G62)
10. Нуруу өвдөх – *Dorsalgia* (M54)
11. Тархины цус багасах дайрлага - *Transient cerebral ischemic attacks* (G45)
12. Тархинд цус харвалт - *Intracerebral hemorrhage* (I61)
13. Аалзавчийн дорх харвалт - *Nontraumatic subarachnoid hemorrhage* (I60)

#### **Халдварт өвчин ба сүрьеэ судлал**

1. Улаан бурхан – *Measles* (B05)
2. Улаан эсэргэнэ – *Scarlet fever* (A38)
3. Салхин цэцэг – *Chicken pox* (B01)
4. Энтеровирусын халдвэр – *Enterovirus infection* (B34.1)
5. Гар хөл амны өвчин – *Hand, foot, mouth disease* (B08.4)
6. Боом – *Anthrax* (A22)
7. Цусан суулга – *Dysenteria* (A03)
8. Сальмонеллээс – *Salmonellosis* (A02)
9. Ротавирусын халдвэр – *Rotaviral infection* (A08.0)
10. Цочмог хепатит – *Acute hepatitis* (B15-B17)
11. Халдварт мононуклёоз – *Infectious mononucleosis* (B27)
12. Менингококкт халдвэр – *Meningococcal infection* (A39)
13. Сүрьеэ – *Tuberculosis* (A15)

### **Чих хамар хоолой, нүд судлал**

1. Зовхины үрэвсэл – *Inflammation of eyelid* (H01–H03)
2. Болорын эмгэг – *Disorders of lens* (H25-H28)
3. Харах эрхтний гэмтэл - *Injury of eye and orbit* (S05)
4. Нүдний салстын үрэвсэл – *Conjunctivitis* (H10)
5. Эвэрлэгийн үрэвсэл – *Keratitis* (H16)
6. Эвэрлэгийн гадны биет - *Foreign body cornea* (T15.0)
7. Миопи – *Myopia* (H52.1)
8. Пресбиопи – *Presbyopia* (H52.4)
9. Нүдний даралт ихсэх эмгэг – *Glucoma* (H40)
10. Болор цайх өвчин – *Cataract* (H25)
11. Дунд чихний үрэвсэл – *Otitis media* (H65)
12. Хэнгэргэн хальсны цооролт – *Perforation of tympanic membrane* (H72)
13. Сонсгал бууралт - *Hearing loss* (H90)
14. Чихний өвдөлт ба булаг – *Otalgia nad effusion of ear* (H92)
15. Хамар, хамар дайврын хөндийн эмгэг - *Disorders of nose and nasal sinuses* (J34)
16. Гүйлсэн булчирхай үрэвсэл – *Tonsillitis* (J35)

### **Арьс судлал, харшил судлал**

1. Энгийн батга – *Acne* (L70)
2. Арьсны идээт өвчнүүд – *Pyoderma* (L08.0)
3. Арьсны мөөгөнцөрт өвчнүүд – *Dermatomycosis* (B35)
4. Бүслүүр үлд – *Herpes zoster* (B02)
5. Хавьтал харшлын дерматит - *Allergic contact dermatitis* (L23)
6. Лайеллын хам шинж – *Toxic epidermal necrolysis [Lyell]* (L51.2)
7. Атопийн дерматит – *Atopic dermatitis* (L20)
8. Экзема – *Eczema* (L20.8)
9. Хайрст үлд – *Psoriasis* (L40)
10. Чонон хөрвөс – *Urticaria* (L50)
11. Анафилаксийн шок – *Anaphylactic shock* (T78.2)
12. Харшлын ринит – *Allergic rhinitis* (J30.9)
13. Эмийн харшил – *Drug allergy* (Z88.8)
14. Хүнсний харшил – *Food allergy* (Z91.01)

### **Сэргээн засах тусlamж үйлчилгээ**

1. Зөөлөн эдийн эмгэгүүд – *Soft tissue disorder* (M79)
2. Тархинд цус харвалт - *Intracerebral hemorrhage* (I61)
3. Мэдрэл булчингийн эмгэгүүд – *Myoneural disorders* (G70)
9. Түлэгдэлт - *Burns and corrosions of external body surface* (T20-T25)
4. Хавдар – *Cancer*
5. Үений гэмтэл – *Joint injuries* (S40-S99)

### **Хавдар ба хөнгөвчлөх тусlamж үйлчилгээ**

1. Хавдар - *Cancer* (liver, stomach, lung, pancreas, bone, breast, prostate)
2. Ясны сийрэгжилт – *Osteoporosis* (M81.0)
3. Чихрийн шижин – *Diabetes mellitus* (E11)

4. Бөөрний архаг дутагдал – *Chronic renal failure* (N18)
5. Зүрхний архаг дутагдал - *Chronic heart failure* (I50)
6. Элэгний дутагдал - *Hepatic failure* (K72)
7. Амьсгалын архаг дутагдал - *Chronic respiratory failure* (J96.1)

### **5.2.3 Гардан үйлдэл**

1. Биеийн ерөнхий үзлэг шинжилгээ- *General physical examination* (89.7)
2. Амьсгал тоолох - *Counting breaths*
3. Зүрхний цохилт тоолох - *Count heart rate*
4. Захын судсанд хүчилтөрөгч тодорхойлох - *Determination of oxygen in the peripheral blood*
5. Шаралт оношлох - *Diagnosis jaundice*
6. Ходоод угаах - *Gastric lavage* (96.33)
7. Байнгын даралттай агаараар амьсгалуулах - *Non-invasive mechanical ventilation* (93.90)
8. Зүрхэнд шууд бус иллэг хийх - *Closed chest cardiac massage* (99.63)
9. Дусал тохируулагч ажиллуулах /перфузор/ - *Perfusor*
10. Цэвэрлэх бургуй тавих - *Other transanal enema* (96.39)
11. Эмчилгээний бургуй тавих - *Proctoclysis* (96.37)
12. Чих дурандах - *Otoscopy* (18.11)
13. Нярайн рефлекс шалгах - *Check infant reflexes*
14. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх - *Screening disability of children*
15. Далд хаван илрүүлэх - *Detect hidden edema*
16. Судасны хүрц (ясанд шингэн сэлбэх хүрц) *Vascular approach*
17. Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор) (ялангуяа нярай, бага насны хүүхдэд) - *Do injection*
18. Ходоодонд хаймсуур тавих (хүнд хэлбэрийн шингэн алдалтын эмчилгээ) - *Gastrostomy* (43.1)
19. Давсганд гуурс байрлуулах - *Cystostomy* (57.17)
20. Шээс бэлгийн эрхтэний анатоми физиологийн хэмжилтүүд болон гар үзлэг - *Anatomic and physiologic measurements and manual examinations genitourinary system* (89.2)
21. Шулуун гэдсийг хуруугаар шинжлэх - *Digital examination of rectum* (89.34)
22. Эх барих, эмэгтэйчүүдийн гадуур үзлэг хийх - *Obstetrics and women's outpatient examination*
23. Умайн ёроолын өндөрийг хэмжих - *Measuring the height of the uterine fundus*
24. Хэвлийн бүслүүрийг хэмжих - *Measurement of abdominal circumference*
25. Ургийн зүрхний цохилт тоолох - *Count fetal heart rate*
26. Ургийн байрлалыг тодорхойлох - *Determination of fetal position*
27. Үтрээнд толь тавьж шинжлэх - *Examining the vagina with a mirror*
28. Умайн ерөндөг тавих - *Insertion of intrauterine contraceptive device* (69.7)
29. Эмэгтэйчүүдийн шинжилгээ - *Gynecological examination* (89.26)
30. Жирэмсний хяналт (Эрүүл, Өртөмхий)- *Prenatal care (Healthy, Susceptible)*
31. Ургийн зүрхний бичлэг хийх - *Fetal ECG (scalp)* (75.32)

- 32.Хэт авиан оношилгоо хийх (жирэмсэнтэй холбоотой анхан шатны үнэлгээ) -  
*Diagnostic ultrasound of gravid uterus* (88.78)
- 33.Настны эрүүл мэндийн хураангуй болон дэлгэрэнгүй үнэлгээ хийх - *Conduct a summary and detailed health assessment of the elderly*
- 34.Глюкометр ашиглан захын цусанд сахар тодорхойлох - *Determination of sugar in peripheral blood using a glucometer*
- 35.Зүрхний цахилгаан бичлэг хийх - *Electrocardiogram* (89.52)
- 36.Гялтангийн хатгалт хийх - *Incision of peritoneum* (54.95)
- 37.Эмийн бодисыг биед оруулах пикфлюметрээр хянах - *Control of the introduction of medicinal substances into the body by picfroumometer*
- 38.Хөшүүн багтрааны үед тусламж үзүүлэх - *Care severe asthma*
- 39.Артерийн даралт хэмжих - *Artery pressure measurement*
- 40.Зүрхэнд шууд бус массаж хийх - *Closed chest cardiac massage* (99.63)
- 41.Зохиомол амьсгал хийх - *Artificial respiration*
- 42.Түргэвчилсэн оношлуур ашиглах - *Use rapid test*
- 43.Туузан оношлуураар шээсний шинжилгээ хийх - *Urinary test in rapid test*
- 44.Давсагт катетр тавих - *Catheter in the bladder*
- 45.Паранефраль хориг тавих - *Paranephric blockade*
- 46.Хэсгийн мэдээ алдуулалт хийх - *Sectional anesthesia*
- 47.Өнгөц мэдээ алдуулалт хийх - *Superficial anesthesia*
- 48.Новокайн хориг хийх - *Novocain blockade*
- 49.Шарх шалгах, цэгцлэх, оёдол тавих - *Suture of laceration*
- 50.Дээд мөчдөд чиг тавих - *Replacement of cast on upper limb* (97.11)
- 51.Захын мэдрэлд өвчин намдаах зорилгоор мэдээгүйжүүлэгч бодис тарих -  
*Injection of anesthetic into peripheral nerve for analgesia* (04.81)
- 52.Симпатик мэдрэлд өвчин намдаах зорилгоор мэдээгүйжүүлэгч бодис тарих -  
*Injection of anesthetic into sympathetic nerve for analgesia* (05.31)
- 53.Доод мөчдөд чиг тавих - *Replacement of cast on lower limb* (97.12)
- 54.Ясны бусад татлага хийх - *Other skeletal traction* (93.44)
- 55.Эгэмний хугаралд хориг хийж засах, 8 тоо хэлбэрийн боолт хийх - *Application of typical eight dressing*
- 56.Мөрний мултрап, бугалганы зөрөөгүй хугаралт ДЕЗО боолт хийх - *Application of Dezo dressing*
- 57.Гөлтгөнөн боолт тавих - *Application of plaster jacket* (93.51)
- 58.Чиг тавих - *Application of splint* (93.54)
- 59.Даралттай боолт хийх - *Application of pressure dressing* (93.56)
- 60.некротоми хийх - *Necrotomy*
- 61.Амьсгалын зам чөлөөлөх - *Release the airway*
- 62.Зүрх уушигны сэхээн амьдруулалт - *Cardiopulmonary resuscitation* (99.60)
- 63.Ходоодонд хаймсуур тавих (хүнд хэлбэрийн шингэн алдалтын эмчилгээ) -  
*Placing a gastric band (treatment of severe dehydration)*
- 64.Мэдрэлийн сорилууд - *Neurologic examination* (89.13)
- 65.Тархины цахилгаан бичлэг хийх - *Electroencephalogram* (89.14)

66. Мэдрэл, мэдрэхүйн эрхтэний анатоми физиологийн хэмжилтүүд болн гар үзлэг - *Anatomic and physiologic measurements and manual examinations nervous system and sense orga* (89.1)
67. Нян судалын шинжилгээнд сорьц авах - *Take samples for bacteriological analysis*
68. Цэрний сорьц цуглуулах - *Collection of sputum specimens*
69. Өнгөт хараа шалгах - *Color vision study* (95.06)
70. Гэрэлд мэдрэмтгий байдал - *Sensitivity to light*
71. Зовхи эргүүлэх - *Turn the blepharon*
72. Нулимын цэгийг сэтгүүрдэх - *Probing of lacrimal punctum* (09.41)
73. Нүдний гэмтлийн илрүүлэх - *Detection of eye injuries*
74. Харааны талбайг шинжлэх - *Visual field study* (95.05)
75. Нүдний уг дурандах - *Ophthalmoscopy* (16.21)
76. Тонографи, сэдээх сорилууд болон бусад нүдний даралт ихдэлтийн сорилууд - *Tonography, provocative tests, and other glaucoma testing* (95.26)
77. Хамар дурандах - *Nasoscopy*
78. Гадны биет авах - *Removal of foreign body* (98.20)
79. Хамрын өмнөд чихээс хийж хамрын цус алдалтыг зогсоох - *Control of epistaxis by anterior nasal packing* (21.01)
80. Сонсгол шалгах эмнэл зүйн сорил - *Clinical test of hearing* (95.42)
81. Харшлын арьс хатгах сорил тавих - *Allergy skin prick test*
82. Үений хөдөлгөөн сайжруулах дасгал - *Training in joint movement* (93.14)
83. Цахилгаан эмчилгээ хийх - *Electricity treatment*
84. Гэрэл эмчилгээ хийх - *Light treatment*
85. Усан эмчилгээ хийх - *Hydrotherapy* (93.33)
86. Бария засал эмчилгээ хийх - *Massage therapy*
87. Паррафин эмчилгээ хийх - *Paraffin treatment*
88. Утлага эмчилгээ хийх - *Incense treatment*
89. Татлага эмчилгээ хийх - *Traction treatment*
90. Арьсан доор дусал эмчилгээ хийх - *Hypodermoclysis*
91. Лидокайныг арьсан доор дуслаар 24 цаг хийх - *Hypodermoclysis in lidocaine*
92. Дурожесик арьсан дээр наах - *Durogesic*
93. Давсганд байнгын катетр тавих - *Indwelling catheter in bladder*
94. Давсганд хатгалт хийх - *Puncture of bladder*
95. Колостомын уут хэрэглэх - *Use colostomy belt*
96. Асцитын шингэн соруулах - *Aspiration of ascites*
97. Биеийн (ерөнхий болон хэсгийн) халуун бууруулах - *Hypothermia (central) (/local)* (99.81)
98. Жирэмсэний дасгал - *Prenatal training* (93.37)
99. Шээлгүүрт тавьсан гуурсыг сольж тавих - *Replacement of ureterostomy tube* (59.93)
100. Цусны эзэлхүүнийг нэмэх шингэн сэлбэх - *Transfusion of blood expander* (99.08)
101. Хөхийг гараар шинжлэх - *Gynecological examination* (89.26)

## Тойролтын хуваарь

<b>№</b>	<b>Тойролтын нэр</b>	<b>Тойролтын хугацаа /7 хоногоор/</b>
1.	Өрхийн эмнэлгийн менежмент, бүтэц зохион байгуулалт	8
2.	Хүүхдэд, өсвөр үеийн эрүүл мэнд	12
3.	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд	3
4.	Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд	5
5.	Наастны эрүүл мэнд	8
6.	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний менежмент	10
7.	Мэс засал	3
8.	Осол гэмтэл	3
9.	Яаралтай тусlamж	3
10.	Сэтгэцийн эрүүл мэнд	4
11.	Мэдрэл судлал	3
12.	Халдварт ба сүрьеэ	4
13.	Чих хамар хоолой, нүд судлал	4
14.	Арьс, харшил судлал	4
15.	Сэргээн засах тусlamж үйлчилгээ	4
16.	Хавдар ба хөнгөвлөх тусlamж үйлчилгээ	8
17.	Гэр бүлийн хүчирхийллийн үеийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ	1
18.	Хөдөлмөрийн чадвар алдалт	1

### **Хяналтын тойрон үзлэг:**

Суралцагч эмч нь хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцсан, өвчтөнтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

### **Сургалтын тойрон үзлэг:**

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг хийнэ. Эмнэл зүйн 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

## **Гардан үйлдэл хийх:**

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багш, бусад эмчийн удирдлага дор эмчилгээг гардан хийнэ. 1 өвчтөнд 30-60 минут зарцуулна. Эмчилгээний явцад эмнэл зүйн шинж тэмдэг, эмчилгээний зарчим, хийх арга зэрэгт суралцана.

## **Тойролтын агуулга**

### **Тойролт 1. Өрхийн эрүүл мэндийн төвийн менежмент, бүтэц зохион байгуулалт**

- Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, өрхийн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, төсөв, төлөвлөлт, зарцуулалт, хяналт
- Эрүүл мэндийн анхан шатны тусlamжийг зохион байгуулах, удирдах
- ЭМАШТУ-нд хэрэгжиж буй хууль, эрх зүй, холбогдох тушаал зааврууд
- Олон улсын эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээний тогтолцоо
- Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг зохион байгуулах

## **Загвар 1**

### **Ажлын байрны сургалт (On-the-Job Training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг	2	7 хоногт 4 удаа, 4 цаг	Өрхийн эрүүл мэндийн төв	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш
Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	2	2 цаг Өдөр бүр	Өрхийн эрүүл мэндийн төв	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш
Өвчиний түүх бичих, амбулаторийн карт бичих	1	7 хоногт 4 удаа 2 цаг	Өрхийн эрүүл мэндийн төв	Компьютер, анхан шатны маягт	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Гардан үйлдэл хийх	1-2	Тохиолдол байгаа үед	Өрхийн эрүүл мэндийн төв	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч

## **Загвар 2**

### **Танхимиын сургалт (Off-the Job Training)**

Сургалтын хэлбэр	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Лекц	15 хүртэл	7 хоногт 1 удаа 4 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Сургагч багш,
Дадлага	15 хүртэл 1 эмчид 2-с илүүгүй	7 хоногт 4 удаа 8 цаг	Сургалтын анги, танхим	Дадлага ажлын хэрэглэгдэхүүн	Сургагч багш, хамтран суралцагч
Бие даалт	3 хүртэл	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч
Журнал клуб	15 хүртэл	7 хоногт 1 удаа 4 цаг	Сургалтын анги, танхим	Дадлага ажлын хэрэглэгдэхүүн	Сургагч багш, хамтран суралцагч

### Загвар 3

#### Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8:30-12:30	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Лекц
12:30-13:30	Цайны цаг				
13:30-15:30	Өвчний түүх бичих, амбулаторийн карт бичих	Өвчний түүх бичих, амбулаторийн карт бичих	Өвчний түүх бичих, амбулаторийн карт бичих	Өвчний түүх бичих, амбулаторийн карт бичих	Журнал клуб
15:30-17:30	Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	
Тохиромжт ой цагт	Гардан үйлдэл Бие даалт	Гардан үйлдэл Бие даалт	Гардан үйлдэл Бие даалт	Гардан үйлдэл Бие даалт	Гардан үйлдэл Бие даалт

#### Тойролт 2. Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд

- Нярайн шарлалт, нярай үеийн зөвлөгөө, гэрийн үзлэг
- Нярайн физиологийн болон эмгэг шарлалтыг ялгаа, тусlamж үйлчилгээг үзүүлэх
- Билиметрээр шарлалт зөв үзэх, дүгнэх, дараагийн шатлалд илгээх
- Хүүхдэд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, анхан шатанд оношилж, цаг алдалгүй дараагийн шатлалд шилжүүлэх
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх
- 5 хүртлэх насны хүүхдийг үнэлж ангилах, эмчилгээ тогтоон, хянах
- Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийг хянах
- Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусlamж
- Эрүүл ба өвчтэй хүүхдийн хооллолтын зөвлөгөө
- Дархлаажуулалт, түүний ач холбогдол, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл
- Өсвөр үеийнхний сэтгэц нийгмийн байдлыг үнэлэх, менежмент хийх
- Өсвөр үеийн хүчирхийлэл

## Загвар 1

### Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг	2	7 хоногт 4 удаа 4 цаг	Өрхийн эрүүл мэндийн төв Дүүргийн хүүхдийн болон өсвөр үеийн кабинет, хэвтэн эмчлүүлэх тасаг	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш
Гэрийн эргэлт, яаралтай дуудлагад явах	2	2 цаг Өдөр бүр		Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш
Өвчний түүх бичих, амбулаторийн карт бичих	1	7 хоногт 4 удаа 2 цаг		Компьютер, анхан шатны маягт	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг Өдөр бүр		Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Гардан үйлдэл хийх	1-2	Тохиолдол байгаа үед		Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч

## Загвар 2

